

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2023-10-04/**

Ажлын хэсгийн 61 дүгээр хуралдаан 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 10 цагт Пума зочид буудлын хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхайн яамны төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнг орлож Статистик судалгааны хэлтсийн дарга Б.Дэлгэржаргал, БОАЖЯ-ны мэргэжилтэн Б.Дулмаа болон Б.Солонго, Ашигт малтмал газрын тосны газрын Бичил уурхайн судалгаа, орон нутаг хариуцсан мэргэжилтэн С.Баттулга, Татварын Ерөнхий газрын байцаагч Ч.Батцэнгэл, Авлигатай Тэмцэх Газрын комисsar М.Мөнхболд, УУХҮЯ-ны Салбарын хяналтын газрын ахлах мэргэжилтэн Ц.Мөнхцэцэг, Нүүрс Ассоциацийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг, Оюутолгой ХХК-ийн ахлах менежер Т.Мөнхбат, Бадрах энержи ХХК-ийн ЭМХАБОТХ-ийн асуудал хариуцсан захирал Ц.Мөнхжаргалыг орлож Энхтулга, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн ахлах нягтлан бодогч Ц.Болормаа, Багануур ХК-ийн Санхүү, Хөрөнгө оруулалт хариуцсан дарга Г.Гансүх, ТАН эвслийн зохицуулагч Ц.Туяацэцэг, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, Хүний эрх хөгжлийн төв ТББ-ын тэргүүн Г.Уранцоож, Эрхүүгийн Улсын Ардын Аж Ахуйн дээд сургуулийг төгсөгчдийн холбоо ТББ-ын тэргүүн Л.Бямбажав, Захиргааны шинэ санаачилга ТББ-ын тэргүүн С.Цэрэнпүрэв, Монголын Байгаль Эхийн Аврал Сангийн тэргүүн Н.Наранцэцэг, МБОИЗ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн Т.Цэрэн, Г.Оюунтуяа нар болон Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон оролцов.

Хуралд Ажлын хэсгийн 33 гишүүнээс 21 гишүүн оролцож ирц 63.6 хувьтай байв.

Мөн хуралдаанд Гроут Финанс Аудит ХХК-ийн аудитор М.Цэрэнлхам болон Т.Ариунжаргал, Авлигатай тэмцэх газрын ахлах ажилтан Д.Цэнд-Аюуш, "Олборлох үйлдвэрлэлийг нээлттэй болгох нь" хөтөлбөрийн зөвлөх А.Батпүрэв, УУХҮЯ-ны СХОГ-ын мэргэжилтэн О.Туяацэцэг, Ая Эс Жи Эс хөтөлбөрийн зөвлөх Х.Батсуурь, Эс Ай Си Ай ХХК-ийн НЭЗСХ-ийн захирал Э.Должин, Менежер Б.Түмэндэлгэржав, Х.Очирбат болон Д.Ганчимэг, ажлын албаны мэдээлэл технологийн зөвлөх С.Болор-Эрдэнэ, харилцааны мэргэжилтэн М.Жавзмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Хуралдааныг УУХҮЯ-ны Статистик, судалгааны хэлтсийн дарга Б.Дэлгэржаргал удирдав.

**Б.Дэлгэржаргал:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр ОҮИТБС-ын ажлын хэсгийн 61 дүгээр хуралдаанаар Монголын ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайлангийн материаллаг байдал, цар хүрээг тодорхойлох, ОҮИТБС-ын суурь мэдээллийд, ажлын даалгаварт шаардсан мэдээллийг ил тод болгох асуудлаар эхлэлийн тайлангийн төслийг Эс Ай Си Эй ХХ-ийн Нийгэм, эдийн засаг, судалгааны хэлтсийн захирал Э.Должин, Олборлох үйлдвэрлэлийг нээлттэй болгох төслийн явцын тухай болон Ашигт хүртэгч эцсийн өмчлөгчийг ил тод болгох Замын зургийн шинэчлэлийн төслийг "Олборлох үйлдвэрлэлийг нээлттэй болгох нь" хөтөлбөрийн зөвлөх А.Батпүрэв нар тус тус

танилцуулна. Хурлын материалыг тараасан байгаа, урьдчилан судалж, товч тодорхой асуулт тавих байх гэж найдаж байна. Хурлаа эхэлье.

**Танилцуулга нэг: Монголын ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайлангийн материаллаг байдал, цар хүрээг тодорхойлох, ОҮИТБС-ын суурь мэдээллүүд, ажлын даалгаварт шаардсан мэдээллийг ил тод болгох асуудлаар эхлэлийн тайлан танилцуулга.**

**Э.Должин:** Сайн байцгаанаа уу, 2 дох жилдээ Гроут Финанс Аудит ХХК-тай хамтран нэгтгэл тайланг боловсруулж байна. Нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй, үндсэн багт 7, туслах багт 4 хүн ажиллаж байна. 2023 оны 8 дугаар сарын 2-нд гэрээ хийгдэж, Ажлын албанаас дата мэдээллүүдийг авснаар өнөөдрийн байдлаар эхлэлийн тайланг гаргасан байна. Та бүхний саналыг нэгтгэж тусгаад дараа дараагийн тайланг хийхээр хуваарийн дагуу төлөвлөгөөд явж байна. Ажлын албанаас компанийн 34, Засгийн газрын 53 нийт 87 файл өгснийг нэгтгэн боловсруулалт хийж өгөгдлийг цэвэрлэсэн. Захиалагч талтай уулзаж, нэгтгэл тайлангийн агуулгыг тодорхойлж, ойлголтоо нэгтгэсэн.

Өмнөх жилүүдийн нэгтгэл тайлантай танилцаж, агуулгыг нарийвчлан судалсан. Захиалагчаас Засгийн газрын хүлээж авсан орлого болон компаниудын тайлагнасан орлогыг багтаасан өгөгдлийг хүлээн авч тус өгөгдлийн цэвэрлэж, нэгтгэн боловсруулсан. 2006 онд 25 компанийн мэдээллийг нэгтгэж байсан бол 2022 онд 63 компанийн мэдээллийг нэгтэн тайлан гаргах ажил явагдаж байсан.

Засгийн газар талаас 2021 онд 1700 компаниас орлого хүлээж авсан мэдээлэл ирүүлж байсан бол 2022 онд 1184 компаниас орлого хүлээж авсан мэдээлэл ирүүлсэн байна. 2019, 2020 болон 2021 оны үзүүлэлтүүдтэй харьцуулахад энэ жил ирүүлсэн мэдээллүүдийн тоо багассан харагдаж байна. 1184 компаниас нийтдээ 4.8 их наяд төгрөгийн орлого хүлээн авсан гэсэн урьдчилсан тооцоо гарсан ба уг дүнгийн 81.5 хувь нь буюу 3.9 их наяд төгрөгийг 100-гаас дээш тэрбум орлого төлсөн 9 компани эзэлж байна. Компани талаас 785 компани мэдээллээ ирүүлсэн нь Засгийн газарт 5.8 их наяд төгрөгийн төлбөр төлсөн гэсэн тооцоолол гарсан. Энэ нь эхний зөрүү дун 1-их наяд 11 тэрбум төгрөг байна. Үүнийг өнгөрсөн жилтэй харьцуулахад механик алдаа баға гарсан нь зөрүү дун багассантай холбоотой гэж үзэж байна.

Эдгээрийг компани нэг бүрээр нь тулган баталгаажуулах боломжгүй тул дараах шалгуур үзүүлэлтээр сонгох төлөвлөгөөтэй байна. Үүнд: 1-р хүчин зүйл нь ажлын даалгаврын дагуу Зэсийн баяжмал, Алт, Нүүрсний олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг, 2-р хүчин зүйл нь Нийт татвар хураамжийн дүн, дүнд эзлэх хувь, 3-р хүчин зүйл нь АМНАТ, АМТЗТ түүнд эзлэх хувь хэмжээг харгалзана, 4-р хүчин зүйл нь Улсын төсвийн орлогод эзлэх хувь, 5-р хүчин зүйл нь өнгөрсөн жилүүдэд хамрагдсан аж ахуйн нэгжийн мэдээлэл байна. Мөн эдгээр дээр нэмэлтээр иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийн саналыг аваал нэмэлтээр хамруулах сонирхолтой байгууллагуудыг оролцуулах төлөвлөгөөтэй байна.

Эхний байдлаар 104 компанийг тулган баталгаажуулахаар санал болгосон байгаа. Компанийн тайлагнасан төлбөрийн мэдээг засгийн газрын тайлагнасан орлогын дүнтэй тохируулсны дараа шинжилж үзэхэд эдгээр 104 компани нь 2022 онд олборлох

үйлдвэрлэлийн компаниудаас Засгийн газрын хүлээж авсан нийт орлогын 97.0 хувийг бүрдүүлсэн байна. 104 компаниас 39 нь алт, 32 нь нүүрс, 3 нь зэс, 30 нь нийт татвар, АМНАТ, АМТЗТ, өндөр төлбөр төлсөн байна. Үүнээс 13.5 хувь нь төрийн болон орон нутгийн оролцоотой, 86.5 хувь нь хувийн компаниуд байна.

17-р нэгтгэл тайланда хамруулахаар төлөвлөж байгаа 104 компани нь өмнөх оны тайлангуудад хамруулсан компаниудаас нийт төлбөрийн эзлэх хувиараа 98.2 хувь буюу хамгийн өндөр хувийг эзэлж байгаа юм. Газрын зурган дээрээс харахад улсын бүртгэлийн хаягаар датаг үүсгэсэн учраас Улаанбаатар хотод түлхүү олон байгууллага байгаагаар харагдаж байна.

Нэгтгэл тайланда орох аж ахуйн нэгжүүдээс Засгийн газрын хүлээн авсан орлогоороо Эрдэнэт ТӨҮГ эхний байрыг эзлэж байна.

Нэгтгэл тайланда орох орлогын бус мэдээллийг цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх үйл явцыг хэрэгжүүлнэ. СЯ, БОАЖЯ, УУХҮЯ, ЗТХЯ, ХНХЯ, АМГТГ, ТӨБЗГ, Татварын Ерөнхий Газар, Аймгуудын Засаг Даргын Тамгын Газар, Аж ахуйн нэгжүүдээс стандарт шаардлагын дагуу мэдээлэл цуглуулан Үндэсний Статистикийн газар, Шилэн Данс зэргээс ирсэн мэдээлэлтэй тулган үзэх төлөвлөгөөтэй байна.

Энэ удаагийн тайлангийн гол зүйлсийн нэг бол эцсийн өмчлөгчийн мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар харуулахыг зорьж байна. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

**Б.Дэлгэржаргал:** Илтгэлтэй холбоотойгоор оролцогдоос асуулт асууж, хариулт авья.

**Ч.Батцэнгэл:** Өнөөдрийн илтгэл тайлан бол цаг үеэ олсон, аргачлал сайтай үйл ажиллагаа болж байна. Үүн дээр лавлах зүйлс байна. Эрдэнэт ТӨҮГ-ийн тайлагнасан болон Засгийн газраас ирүүлсэн мэдээллийн зөрүү нь орон нутгийн төсөвт төлсөн татвараа оруулсан учраас зөрсөн юм болов уу? Энэ бүрийг нэг бүрчлэн, жагсаалтаар авч үзээрэй гэж зөвлөж байна. Засгийн газар дотор гаалийнх болон татварынх гэсэн төрөлтэй байгаа юу? Эсвэл зөвхөн татвараараа зөрж байгаа юу? Аль эсвэл Сангийн яаман дээрх бичилтээрээ зөрж байна уу?

**Э.Должин:** Эхний саналыг хүлээн авлаа, бид цаашдаа энэ тал дээр анхааръя.

**Т.Ариунжаргал:** Бүгдэд энэ өдрийн мэнд, Засгийн газрын мэдээллийн хувьд гааль, татвар, орон нутгийн төсөвт төлсөн татвар бүгд ороод энэ зөрүүг үүсгэж байгаа. 104 компания сонгочдоод нэг бүрчлэн хаана, хаана ямар зөрүү гарсан талаар тодруулга авна гэж төлөвлөж байна.

**Б.Дэлгэржаргал:** Төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэсэн байгаа юу?

**Э.Должин:** Тиймээ, Одоогоор 2 төрийн бус байгууллагаас санал ирсэн байна.

**Ц.Туяацэцэг:** Татварын өр үүссэн байгаа аж ахуйн нэгжүүдийн өр төлбөрийн мэдээлэл хаана байгаа вэ?

**Т.Ариунжаргал:** Эхлэлийн тайлан учраас өр төлбөрийн мэдээлэл ороогүй байгаа. Дараагийн тайлан дээр энэ тухай мэдээлэл орно.

**Г.Уранцоож:** Өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад харьцангуй сайжирсан харагдаж байна. Төрийн бус байгууллагуудын саналыг тусгаж байгаа нь маш сайн байна. Орлогын бус мэдээллийн нийгмийн зардал гэдэгт Орон нутгийн хамтын ажиллагаагаар хийж байгаа үйл ажиллагааг хамруулах хэрэгтэй. Уг мэдээлэл ч мөн адил ил тод байх шаардлагатай.

**Э.Должин:** 17-р тайлан бол өмнөх онуудын тайлангаас илүү дэвшилттэй байх тал дээр анхаарч ажиллаж байна. Үүний нэг нь та бүхний саналыг тусгах нь ажил юм. Таны саналыг хүлээн авлаа.

**Г.Уранцоож:** 785 Компани тайлан гаргасан бол үлдсэн тайлан гаргаагүй байгаа компаниудад ямар хариуцлага байгаа вэ? Үүргээ биелүүлээгүй компаниуд ихэвчлэн давхардсан тоогоор орж байгаа энэ талаар ашигт малтмалын тухай хуульд ямар заалт орсон талаар лавламаар байна.

**Б.Дэлгэржаргал:** Ашигт малтмалын тухай хуулийг Засгийн газарт өргөн барих хэмжээнд хэлэлцүүлэгдээд явж байна. Хариуцлагын асуудлыг одоогоор Зөрчлийн хуулиар шийдэж байна. Засгийн газарт өргөн барьсны дараа ажлын хэсэг дахин зөвлөлдөнө.

**Д.Эрдэнэчимэг:** Төрийн бус байгууллагуудаас авч буй саналыг дэд зөвлөл, орон нутгийн уул уурхай хариуцсан мэргэжилтнээс мөн авч тусгадаг байх хэрэгтэй. Ашигт малтмал газрын тосны газраас дүйцүүлэх байдлаар олгогдож байгаа тусгай зөвшөөрлийн мэдээллийг судалж, хамруулаарай. Компаниудын хувьд олборлох үйлдвэрлэл ил тод байдлын санаачилгын ажлын албанад мэдээлсэн мэдээлэл, улсын бүртгэлд мэдээлсэн мэдээлэл хоёрын дунд зөрүү байна уу гэдгийг нь сайн нягтлаарай. Ашиг хүртэгч эзэмшигч гэж яг ямар ойлголтыг ойлгож байгаа вэ? Мөн улс төрийн ил тод байдал гэсэн байгаа ойлголтыг тайлбарлуулах хүсэлтэй байна.

**Э.Должин:** Эцсийн өмчлөгчийн мэдээллийг шинэчлэгдсэн маятаар авч оруулахаар төлөвлөсөн байгаа. Ажлын албанаас холбогдох мэдээллүүдийг авч ажиллаж байгаа.

**С.Цэрэнпүрэв:** Олборлох үйлдвэрлэлийн стандартын дагуу тайлан хийгдэх ёстой. Өнөөдрийн байдлаар харахад хэтэрхий санхүү чиглэл рүү орсон байна. Олборлох үйлдвэрлэлийн төсөл хэрэгжиж байгаа бусад орны туршлагыг сайн судлаарай. Хөдөлмөр нийгэм хамгааллын яам тайлан гаргахгүй байгаа талаар онцолж үзээсэй гэж хүсэж байна.

**Э.Должин:** Таны саналыг хүлээн авлаа, баярлалаа.

**Л.Бямбажав:** Засгийн газрын мэдээлэл, компанийн мэдээлэл хоёр хоорондоо 40 гаруй хувиар зөрөх нь утгагүй. Яагаад ийм зөрүүтэй байгааг маш сайн нягтлаарай.

**Э.Должин:** Таны саналыг хүлээн авлаа, баярлалаа. Дараагийн хурал дээр зөрүү гарсан газруудаас тодруулга хүсээд, тодорхой тайлбартай орж ирэх болно.

**Т.Цэрэн:** Өнгөрсөн жилийн тайлангаас илүү шат ахисан тайлан болохоор харагдаж байна. 104 компани нь 2022 онд олборлох үйлдвэрлэлийн компаниудаас Засгийн газрын хүлээж авсан нийт орлогын 97.0 хувийг бүрдүүлсэн байгаа нь яг ямар орлогын эзлэх хувь нь вэ?

**Э.Должин:** Засгийн газар талаас 1184 компанийн 4,8 их наяд төгрөг хүлээн авсан гэж тайлагнасан. Үүний 97 хувийг эдгээр 104 компани бүрдүүлсэн байгаа юм.

**Ц.Туяацэцэг:** Компани, татварын ерөнхий газар хоёроос гарсан мэдээллүүд зөрдөг энэ талаар 16-р тайлан дээр гарч байсан. Энэ алдаа мөн давтагдахаар харагдаж байна. Томоохон татвар төлөгч 20 компани хуучнаараа, 1 л шинэ компани нэмэгдсэн байна.

**Э.Должин:** За ойлголоо, баярлалаа.

**А.Батпүрэв:** Орлогын бус мэдээлэл төрийн бус байгууллагаас авахдаа улсын бүртгэлийн ерөнхий газраас компаниудынхаа регистрийг явуулаад тулгалт хийлгэдэг байх саналтай байна.

**Ш.Цолмон:** Өнөөдөр эхлэлийн тайланг эцэслэнэ. Та бүхний өгсөн санал, зөвлөмжийн дагуу ажлаа хийгээд 11 сарын дундуур тайлангийн төслөө танилцуулна. Үүний дараа Үндэсний зөвлөлд танилцуулна.

**Б.Дэлгэржаргал:** Өнгөрсөн жилийн тайлангаас илүү сайжирсан гэж харагдаж байна. 2 дох удаагаа тайлан хийж байгаа багийн хувьд чамлахаар үзүүлэлт байна. Оролцогч нарийн асуултад тийм ч дэлгэрэнгүй хариулсангүй. Дараагийн тайлан дээр дүн шинжилгээний талаар дэлгэрэнгүй тайлбар хийгээрэй мөн удирдах түвшний хүн оролцоосой гэж хүсэж байна.

**Танилцуулга хоёр:** Олборлох үйлдвэрлэлийг нээлттэй болгох төслийн явцын тухай болон Ашигт хүртэгч эцсийн өмчлөгчийг ил тод болгох Замын зургийн шинэчлэлийн төслийн танилцуулга.

**А.Батпүрэв:** Манай төслийн гол мөн чанар нь эцсийн өмчлөгчийг ил тод болгох юм. Дэлхийд нийтдээ 11 улсад төсөл хэрэгжиж байна. 2021 оны 2-р сараас эхлэн дараагийн 5 жилд хүрэх гол үр дүнг танилцуулахад:

1. Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийг олборлох салбарын компаниудын жинхэнэ эздийн талаар иж бүрэн, баталгаатай мэдээллээр хангах орчин бий болгох;

2. Далд өмчлөлөөс үүдэлтэй авлига, муу менежментийн эрсдэлийг илүү хялбараар илрүүлж арга хэмжээ авах боломжийг Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгэмд бүрдүүлэх;

3. Ил болгосноос бий болох үр нөлөөг баримтжуулан сурталчлах замаар олборлох салбар дахь эцсийн өмчлөлийн ил тод байдлыг шат ахиулан хэвшил болгох гэсэн

төлөвлөгөөтэй байна. 2017 онд хэрэгжүүлж байсан замын зураг амжилттай үр дүн гаргаж байсан. Иймд дараагийн замын зургийг гаргах шаардлагатай гэсэн санал зөвлөмжийн дагуу ажлын албатай хамтран 2023 болон 2024 оны замын зургийн төслийг боловсруулсан. Ил тод нээлттэй байдал бүтэн тогтолцоо гэж авч үзвэл дараах 6 бүрдэл хэсэг байна. Үүнд:

1. Голлох оролцогч талуудын ач холбогдол өгөх амлалтыг бататгаж олон нийтэд мэдэгдэх /Амлалт/
  - a. Олборлох компаниудын ЭӨ-ийн ил тод байдлын талаар олон нийтийн ойлголтыг бий болгох, бататгах;
  - b. ЭӨИТБ-ийн ач холбогдол, түүнд өөрсдийнх нь гүйцэтгэх үүргийн талаар оролцогч талуудыг ойлголтыг нэмэгдүүлэх;
2. ЭӨ-ийн ил тод байдлыг бий болгох, дэмжих, хөгжүүлэх хууль эрх зүйн болон бодлогын орчныг шинэчлэн сайжруулах /Эрх зүй/
  - a. ОҮИТБ-ын тухай хуулийг батлуулах;
  - b. ЭӨИТБ-ийг холбогдох Үндэсний бодлого, хууль журамтай холбож уялдуулах;
3. Зөв өгөгдөл цуглуулж ашиглах нөхцөлийг бүрдүүлэн өгөгдлийн чанар, хэрэглээг нэмэгдүүлэх байнгын механизм бий болгох /Өгөгдөл/
  - a. ЭӨ-ийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ил болгох оролцогч талуудыг чадавхыг дэмжих;
  - b. МОҮИТБС-ын хүрээнд ЭӨ-ийн мэдээллийг цуглуулах, харилцан солилцох, ил болгох байгууллагуудын нэгдмэл тогтолцоог бий болгох;
4. ЭӨ-ийн мэдээллийг бүрдүүлж, нийтэд ил болгох үйл ажиллагааны процесс болон мэдээллийн технологийн шийдлийг хөгжүүлэх буюу авч хэрэгжүүлэх /Систем/
  - a. Төрийн холбогдох системүүдийн харилцан хамтын ажиллагааны дагуу олборлох компаниудын ЭӨ-ийн мэдээллийг системтэйгээр байнга ил болгох;
5. Нийтлэг стандартын дагуу нээлттэй лицензтэй өгөгдлийг олон нийтийн хүртээл болгох /Нийтлэх/
  - a. ЭӨ-ийн сайн чанартай мэдээлэл нийтэд ил болох нөхцөлийг бүрдүүлэх;
6. ЭӨ-ийн ил тод байдлын бодлогын үр нөлөөг олон талаас авч үзэн ЭӨ-ийн мэдээллийг судалгаа шинжилгээ, нөлөөлөл, бодлогын шинэчлэл хийхэд өргөнөөр ашиглах /Анхаарч үзэх/
  - a. ЭӨ-ийн мэдээллийг шалган баталгаажуулах болон судалгаа шинжилгээ, нөлөөлөл, бодлогын шинэчлэл зэрэг зорилгоор үр дүнтэй ашиглах оролцогч талуудыг чадавхыг бүрдүүлэх;
  - b. ЭӨИТБ-ын талаарх стандарт шаардлага, хөтөлбөр, зорилт зэргийг тасралтгүй хэрэгжүүлж Олон улсын ОҮИТБС, Нээлттэй Засаглалын Түншлэлийн хүрээн хүлээсэн Монгол Улсын амлалтыг биелүүлэх гэсэн төлөвлөгөөтэй байна.

Уг замын төлөвлөгөөнд сургалтын хуваариуд ороогүй байгаа. Тухай бүрд нь цаг үетэй нь уялдуулан нэмэлтээр оруулах төлөвлөгөөтэй байгаа. Анхаарал хандуулсандаа баярлалаа.

**Б.Дэлгэржаргал:** Оролцогдоос замын зурагтай холбоотой асуулт хариулт авъя.

**Л.Бямбажав:** Ил тод байдлын хууль батлагдаагүй тохиолдолд уг ажил цааш үргэлжлэх боломжтой юу?

**А.Батпүрэв:** Хууль батлагдах нь үйл ажиллагаанд хөшүүрэг болж өгнө. Харин батлагдахгүй байгаа тохиолдолд үйл ажиллагаа саатах, зогсох шалтгаан болохгүй.

**Ц.Туяацэцэг:** Эцсийн өмчлөгчийн асуудал дээр ТАН эвсэл маш идэвхтэй оролцож ирсэн. Замын зураг дээрээс харахад ТББ-уудад хандсан тодорхой төсөвтэй сургалт, үйл ажиллагаа тавигдаагүй байна. Энэ талаар мэдээлэл өгөөрэй.

**А.Батпүрэв:** Иргэний нийгэм, төрийн байгууллага гэсэн тодорхой төлөвлөсөн сургалт одоогоор тооцоолоогүй байна. Тухайн цаг үетэй нь уялдуулан, өөрсдийнх нь хэрэгцээнд тулгуурлан төсөвлөгөөтэй байна.

**Л.Бямбажав:** Эцсийн өмчлөгч гэж хэн бэ? Ямар үндэслэлээр тодорхойлох вэ? Үүрэг хариуцлага нь юу вэ гэсэн ойлголтыг гаргаж тавиад гол үзүүлэлтүүдийг нь нийтэд түгээх саналтай байна.

**А.Батпүрэв:** Одоогийн байдлаар иргэд эцсийн өмчлөгчийн талаар харьцангуй тодорхой ойлголттой болсон. Хууль зүйн хувьд мөн эцэслэгдсэн. Таны саналыг хүлээн авлаа, баярлалаа.

**Д.Эрдэнэчимэг:** Дараах саналуудыг тавьж байна. Үүнд:

1. "Open data Lab"-ийн мэдээллийн санг үргэлжлүүлэн авч явах боломжтой эсэх;
2. Төрийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах сургалт оруулах;
3. Цахим хөгжил, харилцаа, холбооны яамнаас нээлттэй өгөгдлийн жагсаалтаа шинэчилж байгаа 606 мэдээлэл байдаг. Үүнийг яаж нэмж өргөжүүлж болох вэ гэдэг дээр санал хүлээн авч байгаа. Үүнд бид шаардлагатай саналыг хургуулж өөрсдийн авахыг хүссэн мэдээллээ хууль батлагдахыг хүлээхгүйгээр авах боломжтой.

**А.Батпүрэв:** Эцсийн өмчлөгчийн цахим сангийн тухай тендер ажлын алба дээр зарлагдсан байгаа. Энэ ажлыг чанартай гүйцэтгүүлэх тал дээр анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Мөн хөтөлбөрөө таниулах тал дээр ажлын албатай хамтарч ажиллах сонирхолтой байна.

**Д.Цэнд-аюуш:** Авлигатай тэмцэх газар ил тод байдлыг дэмжиж байгаа.

**Д.Эрдэнэчимэг:** Нээлттэй хувьцаат компанийн мэдээллийг ил тод нээлттэй болгохоор ажлын төлөвлөгөөндөө оруулаасай гэж бодож байна.

**А.Батпүрэв:** Одоогийн системд байхгүй байгаа ч цаашдаа энэ чиглэлээр хөгжүүлэх боломжтой гэж бодож байна.

**Б.Дэлгэржаргал:** Олборлох үйлдвэрлэл ил тод байдлын тухай хуулийг их олон жил ярьж байна. Энэ ажлыг УУХҮЯ-ны зүгээс дэмжиж ажиллаж байгаа. Мөн намрын чуулганд

оруулахаар төлөвлөж байна. 2022 оны эхлэлийн тайланг хэлэлцлээ. Гишүүд маань тодорхой нэмж оруулах саналуудыг хэллээ. Үүнийг компани маань хүлээж аваад тодорхой үр дүнгүүд гаргана гэж найдаж байна. Ил тод байдлын замын зургийн ач холбогдлын талаар мэдээлэл авлаа. Өнөөдрийн саналуудыг замын зураг болон эхлэл тайландаа тусгаж засварлаад эргээд дараагийн хурлаар уулзъя. Ажил хэрэгч оролцсонд баярлалаа. Өнөөдрийн хурал хаасныг мэдэгдье.

Хуралдаан 13 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн дарга



С.Магнайсурэн

Хуралдааныг даргалсан:

УУХҮЯ-ны Статистик судалгааны  
хэлтэсийн дарга



Б.Дэлгэржаргал

Тэмдэглэлийг хянасан:

ОҮИТБС-ын ажлын  
албаны зохицуулагч



Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОҮИТБС-ын ажлын албаны  
харилцааны мэргэжилтэн



М.Жавзмаа